

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ, БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ 2019-2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2021 оны 01 дүгээр сарын 28

Багануур дүүрэг

№	Гүйцэтгэх ажлууд	Төлөвлөсөн хугацаа	Биелэлт	Дүгнэлт	Гүйцэтгэл
1.	Тус байгууллагатай уулзалт танилцуулга зохион байгуулж, хамтын ажиллагааны чиглэлийг тогтоон гэрээ байгуулах	2019.05 сар	- 2019.05.06-ны өдөр ХААИС-ийн удирдлагатай Санамж бичиг байгуулж төлөвлөгөө баталсан. - 2020 онд Хамтын ажиллагааны төлөвлөгөөний 4, 6 дахь хэсэгт цар тахалтай холбоотойгоор өөрчлөлт оруулсан.	Цаашид төлөвлөгөөг цар тахалын нөхцөл байдалтай уялдуулан төлөвлөж, инновацийн төслүүдийг хамтран боловсруулах чиглэлээр зорин ажиллана.	100%
2.	ХААИС-ийн эрдэмтэд, судлаач багш нарын инновацийн бүтээгдэхүүний судалгаа явуулж, паркийн үйл ажиллагааны чиглэлээр хэрэгжих боломжтой бүтээлүүдийг түүвэрлэн жагсаалт гаргах	2019-2020	- 2019 онд ХААИС-аас ХХААЯ, ХААИС, ШУТИС-аас хамтран гаргасан Хүнс, хөдөө аж ахуйн салбарын шинжлэх ухаан, технологи, инноваци бүтээгдэхүүний 2016 оны эмхэтгэл, Хөдөө аж ахуйн салбарын 2018 оны инновацийн бүтээгдэхүүний каталоги зэргийг хүлээн авч, паркийн үйл ажиллагааны чиглэлээр хэрэгжих боломжтой төслүүдийг түүвэрлэн авч жагсаалт гаргав. - 2020 онд дээрх түүвэрлэсэн 32 материалд паркийн цаашдын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх боломжтой 10 төслийг мэдээллийн санд оруулсан.	Цаашид он бүрт патентлагдан гарах шинэ бүтээлийн жагсаалтуудыг нэгтгэн мэдээллийн санг баяжуулна.	100%
3.	Паркийн биотехнологийн плантаци, хүнсний бүсэд байгуулах үйлдвэрүүдийн техник, технологитой холбоотой чиглэлээр Улаанбаатар хот болон бүс нутгуудад явагдах эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, үзүүлэх сургалтад оролцох	2019-2020	- 2019 онд ХААИС-аас зохион байгуулсан “Монгол орны эмийн ургамлын судалгаа сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд паркийн Ахлах мэргэжилтэн Д. Алтангэрэл, мэргэжилтэн Д. Оюунсүрэн, нэгж ШУУ-ийн Монхимо ХХК-ийн ерөнхий захирал М. Ариунаа нар оролцож өөрийн паркад биотехнологийн плантаци байгуулах төслийн тухай товч мэдээлэл өгөв. - 2020 онд Эрдэм шинжилгээний хурлыг цар тахалтай холбоотойгоор тус байгууллага зөвхөн харьяа сургуулиудын хүрээнд зохион байгуулсан.	Цаашид эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнд оролцоно.	100%
4.	Эрдэм шинжилгээний байгууллага, их дээд, сургууль, тариаланчид, иргэдийг	Жил бүрийн 06 сар	- Багануурт биотехнологийг эрчимтэй хөгжүүлэх суурь бэлтгэлийг хангах, дүүргийг Эко-Хот болгон хөгжүүлэх санаачлагын хүрээнд “Эмийн ургамал,	Цаашид сургалт, нээлттэй өдөрлөг зэрэг арга хэмжээг цар тахалын нөхцөл	50%

	хамруулсан “Эмийн ургамал, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо тариалах нь” сэдэвт хамтарсан сургалт, зөвлөгөөн, нээлттэй өдөрлөгийг Багануурт зохион байгуулах		<p>жимс жимсгэнэ тариалах нь” сэдэвт уулзалт зөвлөгөөнийг ХААИС, УХЭШХ, ШАУИС, Монхимо ХХК-тай хамтран дүүрэгтээ 2019.06.21-ны өдөр зохион байгуулж, 40 гаруй хүн оролцож, 8 илтгэлийг тавьж, хэлэлцүүлэн санал зөвлөмжүүдийг өгөв. Тус зөвлөгөөнд тавигдсан илтгэлүүдийн жагсаалтыг хавсаргав.</p> <p>- Тус арга хэмжээг 2020 онд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан ч цар тахалтай холбоотойгоор тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан.</p>	байдалтай уялдуулан төлөвлөж зохион байгуулна.	
5.	Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар бордоо хийх, үр дүнг шинжлэх, талбайн туршилт явуулахад мэргэжлийн зөвлөгөө өгөх	Жил бүрийн 06, 09 сар	<p>2019 онд дараах ажлыг зохион байгуулсан. Үүнд:</p> <p>- “Эко тусгал” ХХК-ийн үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар хийсэн бордооны технологи, туршилтын үр дүнд тулгуурлан паркийн плантацийн хөрсний компост бордооны үйлдвэрийг эхлүүлэх суурь судалгааг хийх, дүүргийн ахуйн хог хаягдлыг бууруулах ажлын хүрээнд үйлдвэрлэл, технологийн албаны инженер мэргэжилтнүүд 19 байгууллагын 400 гаруй албан хаагчдад танхимын сургалтыг, шинээр 5 өрхөд үзүүлэх сургалтыг зохион байгуулсан.</p> <p>- “Эко тусгал” ХХК-ийн туршилтын бордоог Агроэкологийн сургуулийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. Уг бордоог цэцэрлэгжүүлэлт, уул уурхайн нөхөн сэргээлт, газар тариалан эрхлэлтэд болон хүнсний ногоо тариалалтад ашиглахад тохиромжтой.</p> <p>- Хог хаягдлаар хийсэн дээрх бордоог Багануур-Тохижилт ОНӨААТҮГ нь автомагистраль замын дагуу тарьсан 110 ш модондоо ашиглаж, туршилтыг эхлүүлсэн.</p> <p>2020 онд дараах ажлыг зохион байгуулсан. Үүнд:</p> <p>- Автомагистраль замын дагуу тарьсан 110 ш модны ургах явцад улирал бүр хяналт тавьж ажилласан. Тус талбайн хайрга, чулуу ихтэй газар төлөвлөгдсөн байсан тул 18ш мод өсөлтгүй зогссон.</p>	Цаашид бордоо бэлтгэх чиглэлийн эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнд оролцох, бэлтгэх аргачлалыг цахимаар хүргэх, цахим сургалт зохион байгуулах зэрэгт анхаарч ажиллана.	100%

			<ul style="list-style-type: none"> - 05, 10 дугаар сард 2019-2020 онуудад үзүүлэх сургалт хийсэн 6 айл өрхийн компост бордоог газар дээр нь үзэж танилцан, зөвлөгөө өгч ажилласан. - 2020 оны 03 сарын 04-ний өдөр цэвэрлэх байгууламжийн лагийг бордоо болгон үйлдвэрлэх технологийн мэдээллийг “Эко Тайхи” ХХК-ий менежер Ш.Болдсайхан-аас авч, хог хаягдлаар бордоо үйлдвэрлэдэг технологитой хоршуулах боломжийн талаар санал солилцов. 		
6.	Паркийн эмийн ургамлын плантаци байгуулах талбайн хөрсний шинжилгээ хийлгэхэд дэмжлэг үзүүлэх	2019.09 сар	2020 онд гүйцэтгэхээр төлөвлөсөн ч Ковид-19 цар тахалтай холбоотойгоор цуцалсан.	Цаашид хамтран зохион байгуулах арга хэмжээг цар тахалын нөхцөл байдалтай уялдуулан төлөвлөж ажиллана.	-
7.	Плантацид тариалахад тохиромжтой ховор эмийн ургамлуудын судалгаа явуулж, гербари цуглуулга хийхэд дэмжлэг үзүүлэх	2019-2020	2020 онд Паркийн хувьд плантацид тариалахад тохиромжтой ховор эмийн ургамлуудын гербари цуглуулга хийхэд талаар эрдэмтэн судлаачдаас зөвлөгөө авсан.	Цаашид парк гербари цуглуулга хийх ажлыг эрчимжүүлж, баяжуулах зорилготой ажиллана.	70%
8.	Байгууллагуудын хамтарсан “Бүтээлч-Аялал” зохион байгуулах Үүнд: → Дарханы эрдэм шинжилгээний хүрээлэн → Хэрлэнбаян-Улаан болон Хөх нуурын биостанцын ховор ургамлын тариалан	2019-2020 06, 09 сар	<ul style="list-style-type: none"> - 06.21-22-ны өдрүүдэд зөвлөгөөнд оролцсон эрдэмтэн, судлаачидтай хамтран Хэрлэнбаян-Улаан болон Хөх нуурын биостанцын ховор ургамлын плантацитай танилцаж, туршлага судлаж, 18 хүн оролцсон бүтээлч аялалыг зохион байгуулав. - Плантаци байгуулсан газар орон, цаг уур, хөрсний байдлыг үзэж, плантацийн ерөнхий зохион байгуулалттай танилцав. - 2020 онд Дарханы эрдэм шинжилгээний хүрээлэнтэй танилцах арга хэмжээг зохион байгуулах байсан ч Ковид-19 цар тахалтай холбоотойгоор цуцалсан. 	<ul style="list-style-type: none"> - ШАУИС, ХААИС-ийн багш судлаачид өөрийн плантацийн үйл ажиллагаатай танилцуулсан маш үр дүнтэй, туршлага хуримтлуулсан бүтээлч аялал боллоо. - Хэрлэнбаян-Улааны плантацийн газар орон нь Баганууртай ижил төстэй байгаа нь парсад плантаци байгуулахад боломжтой харагдлаа. - Цаашид хамтран зохион байгуулах арга хэмжээг цар тахалын нөхцөл байдалтай уялдуулан төлөвлөж ажиллана. 	100%
Хэрэгжилтэд тооцох боломжгүй арга хэмжээний тоо					2

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.МӨНГӨНХУЯГ

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
КЛАСТЕР ИНЖЕНЕР

Э. ЭНХЗАЯА